



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/135

Хужирт сум

Коронавируст халдвар (COVID-19)-ын үед  
ор нэмэлтээр дэлгэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 10.4.4, 18 дугаар зүйлийн 18.4, 32 дугаар зүйлийн 32.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед эмнэлэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зураглал, батлах туай” А/101 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Коронавируст халдвар (COVID-19)-ын үед нэмэлтээр ор дэлгэх тухай” А/75 дахь захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд коронавируст халдвар (COVID-19)-ын тоо нэмэгдэж байгаа тул тусгаарлах эмнэлэгт нэмэлтээр 60 ор дэлгэсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ